

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өнөр бүл хүүхдийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/189/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 99004895 Цахим хаяг: tsogbayar.a@audit.mn Аудитор : Д.Номингуа Утас: 99189344 Цахим хаяг: nominguad@audit.gov.mn Ихмонгол хөлөг аудит ХХК-ийн захирал: Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
3.5.1 Төсвийн төлөвлөлт	18
3.5.3 Нэмэлт төсөв.....	20
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	20
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	22
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал.....	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	23
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.5.1 Завсрын аудитын талаар.....	24
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НХМаягт	Нэг хэвийн маягт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ӨНӨР БҮЛ ХҮҮХДИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ М.ӨЛЗИЙЧИМЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/423
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өнөр бүл хүүхдийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 249,888.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Өнөр бүл хүүхдийн төвийн захирлын “Байгууллагын эд хөрөнгө, бараа материалын тооллого хийх ажлын хэсэг байгуулах тухай” 2025 оны 12 угаар сарын 09-ны өдрийн А/41 дүгээр тушаалыг хэрэгжүүлээгүй, нийт 11,077,772.1 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлд тооллогыг хуулийн хугацаанд хийгээгүй, тооцоог бодож баталгаажуулаагүй;
- Шалгагдагч байгууллагын асруулагчдын хоолны зарцуулалтыг давтан тооцоолоход 62,223.7 мянган төгрөгийг батлагдсан нормоос зөрүүтэй тооцсон, батлагдсан төсөвгүй баяр ёслол тэмдэглэхэд нийт 144,546.0 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан.
- Ашиглалтад байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 144,065.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж,

ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр тайлагнаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1,16 дугаар зүйлийн 16.5.5, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1,13.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2, 70 дугаар зүйлийн 70.2, 70.5, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дах заалт, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/130 тушаалын 1,2,3,4 дүгээр хавсралт, ТӨБЗГ-ын 2019 оны 171 дүгээр тогтоолын 6.2.1-д тус тус заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх, "Эрх ба үүрэг", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Олон улсын "Холт интэрнэшнль" Төрийн бус байгууллагатай жил бүр гэрээ байгуулан 88,369.3 мянган төгрөгийн хүүхдийн дархлааг дэмжин, амин дэмтэй хоол хүнс, олон нэрийн чанартай бүтээгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол улсын Засгийн газрын 2024 оны 121 дүгээр тогтоолын дагуу тайлант онд 14-өөс дээш насны 78 хүүхдийн мөнгөний 80 хувиар банкны хадгаламжийн данс, 20 хувийг өөрөө захиран зарцуулах зориулалт бүхий данс нээлгэж цахим карттай болгосон байна.

Бусад асуудал

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хяналт шинжилгээ үнэлгээний газраас байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн тайланд үнэлгээ хийж, нийт 3 үндсэн зорилтын хүрээнд 45 хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн 98.1 хувийн хэрэгжилттэй дүгнэсэн байна.

Өнөр бүл хүүхдийн төвд асруулагч нийт 145 хүүхдээс 93 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд, 52 хүүхэд цэцэрлэгт хүмүүжиж байна.Тайлант онд тус төвд 9 хүүхэд шинээр ирж, 14 хүүхэд 18 нас хүрч халамжийн дараах үйлчилгээнд, 4 хүүхэд гэр бүлдээ нэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	394,093,070.01	397,613,843.71
33	АВЛАГА	600,000.00	111,849.46
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	600,000.00	111,849.46
35	БАРАА МАТЕРИАЛ	393,493,070.01	397,501,994.25
35100	Түүхий эд материал	2,837,050.45	-
35110	Тусгай зориулалттай материал	2,656,000.00	-
35130	Эм боох материал	181,050.45	-
35400	Хангамжийн материал	390,656,019.56	397,501,994.25
35410	Бичиг хэргийн материал	3,489,500.00	3,485,880.00
35420	Аж ахуйн материал	7,811,624.00	8,528,020.00
35430	Сэлбэг хэрэгсэл	24,709,631.61	720,000.00
35440	Түлш, шатах тослох материал	6,353,582.75	2,631,531.75
35450	Барилгын засварын материал	770,000.00	-
35460	Хүнсний материал	255,778,488.70	238,829,248.60
35470	Бусад хангамжийн материал	91,743,192.50	143,307,313.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,681,479,611.22	8,426,091,246.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,681,479,611.22	8,426,091,246.96
39200	Биет хөрөнгө	8,202,242,051.22	7,946,853,686.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,782,843,504.00	8,782,843,504.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,363,974,800.84)	(1,564,099,179.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	425,978,000.00	425,978,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(284,998,000.00)	(299,446,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	504,297,953.00	561,364,125.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(117,224,520.37)	(189,940,900.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	242,138,046.00	258,567,046.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,318,932.79)	(69,280,326.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	169,568,787.00	146,229,587.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(152,519,612.78)	(131,359,419.34)
39217	Ном	28,451,628.00	25,997,250.00
39300	Биет бус хөрөнгө	479,237,560.00	479,237,560.00
39303	Бусад биет бус хөрөнгө	479,237,560.00	479,237,560.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	9,075,572,681.23	8,823,705,090.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	4,517,745.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,517,745.00
41300	Өглөг	-	4,517,745.00
41360	Бусад өглөг	-	4,517,745.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	4,517,745.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,075,572,681.23	8,819,187,345.67
51	Засгийн газрын хувь оролцоо	9,075,572,681.23	8,819,187,345.67
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,746,814,042.00	1,746,814,042.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,746,814,042.00	1,746,814,042.00
51200	Хуримтлагдсан үр дүн	4,763,084,977.39	4,506,699,641.83
51210	Өмнөх үеийн үр дүн	3,579,936,701.92	4,763,084,977.39
51220	Тайлант үеийн үр дүн	1,183,148,275.47	(256,385,335.56)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,565,673,661.84	2,565,673,661.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	9,075,572,681.23	8,823,705,090.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	6,426,390,451.97	5,108,786,455.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,185,961,451.97	5,108,786,455.65
120	Нийтлэг татварын бус орлого	1,185,961,451.97	185,945,146.65
120009	Бусад орлого	-	426,855.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,070,186,851.00	75,712,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	115,774,600.97	109,805,791.65
122	Тусламжийн орлого	-	4,922,841,309.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	4,922,841,309.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,907,841,309.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	4,907,841,309.00
12212	Харъяа төсвийн байгууллагаас төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн орлого	-	15,000,000.00
122123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн орлого\	-	15,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,240,429,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,198,459,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,198,459,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,970,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,315,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,655,000.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,241,092,398.78	5,362,717,413.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,241,092,398.78	5,362,717,413.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,043,719,374.27	5,241,653,799.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,825,164,025.38	2,991,761,295.31
210101	Үндсэн цалин	1,359,316,891.64	1,586,736,906.60
210102	Нэмэгдэл	848,821,655.36	744,504,901.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	456,210,181.91	491,319,742.17
210104	Урамшуулал	160,815,296.47	169,199,745.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	343,001,581.89	355,927,670.23
210201	Тэтгэврийн даатгалын зардал	227,655,881.89	225,636,170.23
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	28,836,400.00	32,572,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	14,418,200.00	16,286,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	14,418,200.00	16,286,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	57,672,900.00	65,145,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,504,373.41	198,186,193.72
210301	Гэрэл, цахилгаан	42,246,033.38	65,307,165.67
210302	Түлш, халаалт	65,329,742.00	75,022,650.13
210303	Цэвэр, бохир ус	23,928,598.03	57,856,377.92
2104	Хангамж, бараа материалын зардал	105,396,479.00	98,176,924.32
210401	Бичиг хэрэг	31,671,820.00	19,531,270.00
210402	Тээвэр, шатахуун	19,639,706.00	18,407,216.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,752,703.00	2,694,354.32
210404	Ном, хэвлэл	101,200.00	117,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,942,800.00	3,529,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,288,250.00	53,897,084.00
2105	Нормативт зардал	1,093,901,290.27	1,154,818,725.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,877,364.60	15,252,810.45
210502	Хоол, хүнс	757,981,828.17	903,592,836.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	312,042,097.50	235,973,078.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	129,296,120.00	59,495,931.61
210604	Урсгал засвар	129,296,120.00	59,495,931.61
2107	Томилолт, зочны зардал	1,584,000.00	980,000.00
210702	Дотоод албан томилолт	1,584,000.00	980,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,481,950.00	11,854,722.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,932,470.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,139,200.00	3,150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,484,000.00	1,689,282.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	521,600.00	2,175,840.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,502,000.00	4,590,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	847,680.00	128,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	321,389,554.32	370,452,336.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,490,068.64	10,268,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,954,800.00	6,307,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	246,944,685.68	353,876,486.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	197,373,024.51	121,063,613.96
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	96,902,604.96
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	96,902,604.96
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	96,902,604.96
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	81,902,604.96
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	15,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,431,400.00	24,161,009.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,959,900.00	23,671,009.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,471,500.00	490,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	126,941,624.51	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	126,936,624.51	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,185,298,053.19	(253,930,957.56)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,149,777.72	2,454,378.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	2,149,777.72	2,454,378.00
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(2,149,777.72)	(2,454,378.00)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,183,148,275.47	(256,385,335.56)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	5,240,429,000.00	4,922,841,309.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,922,841,309.00
122	Тусламжийн орлого	-	4,922,841,309.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	4,922,841,309.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,907,841,309.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	4,907,841,309.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	15,000,000.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,240,429,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,198,459,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,198,459,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,970,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,315,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,655,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,209,567,295.00	4,897,611,309.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,209,567,295.00	4,897,611,309.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,012,194,270.49	4,776,547,695.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,829,699,685.35	2,991,273,144.77
210101	Үндсэн цалин	1,363,852,551.61	1,586,248,756.06
210102	Нэмэгдэл	848,821,655.36	744,504,901.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	456,210,181.91	491,319,742.17
210104	Урамшуулал	160,815,296.47	169,199,745.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	343,001,581.89	355,927,670.23
210201	Тэтгэврийн даатгалын зардал	227,655,881.89	225,636,170.23
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	28,836,400.00	32,572,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	14,418,200.00	16,286,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	14,418,200.00	16,286,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	57,672,900.00	65,145,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,504,373.41	198,184,003.72
210301	Гэрэл, цахилгаан	42,246,033.38	65,307,165.67
210302	Түлш, халаалт	65,329,742.00	82,529,957.80
210303	Цэвэр, бохир ус	23,928,598.03	50,346,880.25
2104	Хангамж, бараа материалын зардал	123,565,582.00	83,550,997.32
210401	Бичиг хэрэг	22,991,100.00	16,471,150.00
210402	Тээвэр, шатахуун	23,516,000.00	14,260,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,752,703.00	2,343,767.32
210404	Ном, хэвлэл	23,523,300.00	117,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,712,800.00	5,384,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,069,679.00	44,973,580.00

2105	Нормативт зардал	1,163,108,115.20	1,084,959,797.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,076,690.20	12,005,597.00
210502	Хоол, хүнс	849,166,725.00	792,822,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	297,864,700.00	280,132,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	269,455,009.00	30,934,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,799,000.00	-
210604	Урсгал засвар	260,656,009.00	30,934,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,584,000.00	980,000.00
210702	Дотоод албан томилолт	1,584,000.00	980,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,813,930.00	10,792,632.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,264,450.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,139,200.00	3,150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,484,000.00	627,192.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	521,600.00	2,175,840.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,502,000.00	4,590,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	847,680.00	128,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,461,993.64	19,944,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,475,983.64	12,353,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,986,010.00	7,591,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	197,373,024.51	121,063,613.96
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	96,902,604.96
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	96,902,604.96
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	96,902,604.96
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	81,902,604.96
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	15,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,431,400.00	24,161,009.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,959,900.00	23,671,009.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,471,500.00	490,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	126,941,624.51	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	126,936,624.51	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	30,861,705.00	25,230,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	30,861,705.00	25,230,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,861,705.00	25,230,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,861,705.00	25,230,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,861,705.00	25,230,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(30,861,705.00)	(25,230,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,746,814,042.00	2,882,902,902.55	3,262,707,461.21	7,892,424,405.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	317,229,240.71	317,229,240.71
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,746,814,042.00	2,882,902,902.55	3,579,936,701.92	8,209,653,646.47
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(317,229,240.71)	-	(317,229,240.71)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,183,148,275.47	1,183,148,275.47
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,746,814,042.00	2,565,673,661.84	4,763,084,977.39	9,075,572,681.23
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,746,814,042.00	2,565,673,661.84	4,763,084,977.39	9,075,572,681.23
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(256,385,335.56)	(256,385,335.56)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,746,814,042.00	2,565,673,661.84	4,506,699,641.83	8,819,187,345.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,191,122,000.00	4,825,938,704.04	365,183,295.96	93.0
12	Татварын бус орлого	5,191,122,000.00	4,825,938,704.04	365,183,295.96	93.0
122	Тусламжийн орлого	5,191,122,000.00	4,825,938,704.04	365,183,295.96	93.0
122005	Төсвөөс санхүүжих	5,191,122,000.00	4,825,938,704.04	365,183,295.96	93.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,191,122,000.00	4,825,938,704.04	365,183,295.96	93.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,191,122,000.00	4,825,938,704.04	365,183,295.96	93.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,136,162,500.00	4,801,777,695.04	334,384,804.96	93.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,188,757,600.00	2,991,273,144.77	197,484,455.23	93.8
210101	Үндсэн цалин	1,578,223,900.00	1,586,248,756.06	(8,024,856.06)	100.5
210102	Нэмэгдэл	938,855,200.00	744,504,901.41	194,350,298.59	79.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	414,546,700.00	491,319,742.17	(76,773,042.17)	118.5
210104	Урамшуулал	257,131,800.00	169,199,745.13	87,932,054.87	65.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	404,722,600.00	355,927,670.23	48,794,929.77	87.9
210201	Тэтгэврийн даатгал	274,431,100.00	225,636,170.23	48,794,929.77	82.2
210202	Тэтгэмжийн даатгал	32,572,800.00	32,572,800.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,286,500.00	16,286,500.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	16,286,500.00	16,286,500.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	65,145,700.00	65,145,700.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	210,305,800.00	198,184,003.72	12,121,796.28	94.2
210301	Гэрэл, цахилгаан	85,062,000.00	65,307,165.67	19,754,834.33	76.8
210302	Түлш, халаалт	72,583,000.00	82,529,957.80	(9,946,957.80)	113.7
210303	Цэвэр, бохир ус	52,660,800.00	50,346,880.25	2,313,919.75	95.6
2104	Хангамж, бараа материалын зардал	95,777,000.00	83,550,997.32	12,226,002.68	87.2
210401	Бичиг хэрэг	16,511,200.00	16,471,150.00	40,050.00	99.8
210402	Тээвэр, шатахуун	16,676,200.00	14,260,500.00	2,415,700.00	85.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,874,100.00	2,343,767.32	2,530,332.68	48.1
210404	Ном, хэвлэл	117,200.00	117,200.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,278,100.00	5,384,800.00	9,893,300.00	35.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,320,200.00	44,973,580.00	(2,653,380.00)	106.3
2105	Нормативт зардал	1,128,152,700.00	1,084,959,797.00	43,192,903.00	96.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,045,900.00	12,005,597.00	3,040,303.00	79.8
210502	Хоол, хүнс	821,862,400.00	792,822,000.00	29,040,400.00	96.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	291,244,400.00	280,132,200.00	11,112,200.00	96.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,164,800.00	56,164,800.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,230,000.00	25,230,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	30,934,800.00	30,934,800.00	-	100.0
2107	Томилт, зочны зардал	1,639,700.00	980,000.00	659,700.00	59.8
210702	Дотоод албан томилт	1,639,700.00	980,000.00	659,700.00	59.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,674,100.00	10,792,632.00	10,881,468.00	49.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,886,000.00	-	5,886,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,150,000.00	3,150,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,783,900.00	627,192.00	1,156,708.00	35.2

210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,175,900.00	2,175,840.00	60.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	216,800.00	121,000.00	95,800.00	55.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,897,600.00	4,590,500.00	2,307,100.00	66.6
210807	Газрын төлбөр	802,900.00	-	802,900.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	761,000.00	128,100.00	632,900.00	16.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,968,200.00	19,944,650.00	9,023,550.00	68.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,353,200.00	12,353,200.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,615,000.00	7,591,450.00	9,023,550.00	45.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,959,500.00	24,161,009.00	30,798,491.00	44.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,959,500.00	24,161,009.00	30,798,491.00	44.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	54,469,500.00	23,671,009.00	30,798,491.00	43.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	490,000.00	490,000.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	94	94	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	70	70	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	23	23	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	94	94	-	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	56	56	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	6	6	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	32	32	-	100.0
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	3	3	-	100.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	3	3	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	15,000,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	15,000,000.00
122	Тусламжийн орлого	-	15,000,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	15,000,000.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	15,000,000.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,000,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төвийн зорилго нь “Эцэг эх гэр бүлтэйгээ амьдрах боломж нь хязгаарлагдсан хүүхдийг гэр бүлд дүйцэхүйц ээлтэй орчинд эсэн мэнд амьдрах, сурч боловсрох, хөгжих, нийгмийн амьдралд оролцох, хамгаалуулах үндсэн эрхийг ханган, өсгөн хүмүүжүүлж, амьдрах чадвартай иргэн болгон төлөвшүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон.

Өнөр бүл хүүхдийн төв нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.Тухайлбал:

- Хүүхдэд бие даан амьдрах чадвар, дадал олгох, үндэсний зан заншилд суралцуулан ёс зүйтэй, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн хүүхэд бүрийн нас бие сэтгэл зүйн онцлогт тохирсон хөтөлбөр арга зүй хэрэгжүүлэх;
- Мэдлэг чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлж, мэргэжлийн үйлчилгээг хүүхэд бүрд тэгш хүртээмжтэй хүргэх;
- Хүүхэд бүрийн хэвийн эрүүл өсөлтийг дэмжин, зохистой хоол хүнсээр ханган, бие бялдар, сэтгэхүй болон сэтгэл санааны хувьд эрүүл тайван байх нөхцөлийг бүрдүүлэх;
- Хүүхдийг сургуулийн өмнөх бага дунд суурь боловсролд заавал хамруулж, дугуйлан секцэд сонирхлын дагуу оролцуулж, хөгжлийн явц, өөрчлөлт, хичээлийн хоцрогдлыг үнэлэх ба эерэг өөрчлөлтийг олгоход чиглэсэн төлөвлөгөө гарган ажиллах;
- Үйлчлүүлэгч хүүхдийн мэдээллийн санг бүрдүүлж, шилжилт хөдөлгөөний тэмдэглэлийг нарийн хөтөлж, халамжийн дараах үйлчилгээнд хяналт тавьж ажиллах;
- Хүүхдийн гарал угсаа, төрөл саднаа мэдэх, тэдэнтэй харилцах боломжийг бүрдүүлэх;
- Түр хамгаалах байр, яаралтай тусламжийн үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн ар гэр, асран хамгаалагчийг тогтоохоор цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа явагдаж байх хугацаанд хүүхдийг түр асрамжлах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өнөр бүл хүүхдийн төв нь төрөөс зайлшгүй асран хамгаалах хэрэгцээ үүссэн 03-18 хүртэлх насны бүтэн өнчин, хаягдсан, эцэг эх нь сэтгэцийн өвчтэй, хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан нь тогтоогдсон, эцэг эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан гэр бүлийн хүүхдийг хүлээн авч гэр бүлд дүйцэхүйц хөгжил, хамгааллын болон хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Өнөр бүл хүүхдийн төв нь Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Ахмад настны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай

хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуйн тухай хууль, Төрийн албаны тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 5 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолыг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдсөн;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн батлагдсан;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/197 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Өнөр бүл хүүхдийн төвийн бүтэц орон тооны хязгаарт дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтны орон тоог батлаагүй, дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтангүй байна. Төвийн захирлын 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/37 дугаар тушаалаар Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний багийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, 4 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, хэрэгжилтийг 100 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.Хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөсөн ажлын 61 хувь нь үндсэн үйл ажиллагаанд чиглэгдсэн байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/252 дугаар тушаалаар тус төвийн 2024-2025 оны үйл ажиллагаанд гадаад дотоодын иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хандив, тусламжийн шугамаар хүлээлгэн өгсөн бараа материал, эд хөрөнгийн бүртгэл, зарцуулалтын байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, цаашид авах арга хэмжээний талаар 10 зөвлөмж хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Өнөр бүл хүүхдийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж үнэн зөв толилуулсан эсэхэд санал дүгнэлт өгөхөд чиглэнэ.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2020 оны 12 дүгээр сарын 07 -ны өдрийн А/ 37 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг байна.

Уг баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн боловч санхүүжилт, дотоод хяналт, үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй, ерөнхий байдлаар боловсруулсан, шинээр батлагдан гарч буй стандарт, хууль тогтоомж, заавар, журамтай нийцүүлэн шинэчлэлт өөрчлөлт хийгдээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өнөр бүл хүүхдийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 251,867.6 мянган төгрөгөөр буюу 29.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	600.0	111.8	(488.2)
Бараа материал	393,493.1	397,502.0	4,008.9
Үндсэн хөрөнгө	8,681,479.6	8,426,091.2	(255,388.4)
Нийт хөрөнгө	9,075,572.7	8,823,705.0	(251,867.7)
Өр төлбөр		4,517.7	4,517.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,075,572.7	8,819,187.4	(256,385.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,075,572.7	8,823,705.1	(251,867.6)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Авлага дансны үлдэгдэл нь 111.8 мянган төгрөг болж 488.2 төгрөгөөр буурсан нь өмнөх оны хувь хүмүүсээс авах 600.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, тайлант онд нийгмийн даатгалын байгууллагад 111.8 мянган төгрөгийг илүү шилжүүлснээс шалтгаалжээ.
- Бараа материалын дансны үлдэгдэл нь өмнөх оноос 4,008.9 мянган төгрөгөөр өссөн нь 1,187,978.1 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 3 аж ахуйн нэгж, байгууллагаас 91,796.1 мянган төгрөгийн, 19 иргэнээс 18,436.5 мянган төгрөгийн, нийт 110,232.5 мянган төгрөгийн хүнсний болон аж ахуйн материалыг хандиваар хүлээлгэн өгсөн, үйл ажиллагаанд 1,294,201.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 255,388.4 мянган төгрөгөөр буурсан нь бөгөөд тайлант хугацаанд дараах хөдөлгөөн өөрчлөлтүүд орчээ.

Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 25,230.0 мянган төгрөгийн 2 нэр төрлийн тоног төхөөрөмжийг худалдан авч, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газраас 36,208.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 8 иргэнээс 39,504.0 мянган төгрөгийн 17 нэр төрлийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, нийт 75,712.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгийг хүлээн авч дансанд бүртгэсэн.
- Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/615 тоот тушаалаар 14 нэр төрлийн 53,240.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан.
- Тайлант хугацаанд 353,876.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 4,517.7 мянган төгрөгөөр өссөн нь санхүүжилтийн эх үүсвэргүйгээс нийт 8 байгууллагад 4,517.7 мянган төгрөгийн гэрээний төлбөрийг барагдуулаагүй нь нөлөөлжээ.
- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 251,867.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад тус төв нь санхүүгийн “Acolaus” программ, хангамжийг 2016 оноос ашиглаж байгаа ба дэлгэрэнгүй судалгааг маягтаар баталгаажуулж, баримтжууллаа.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,536,898.1 мянган төгрөг, нийт зарлагыг 6,536,898.1

мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас, дотоод албан томилолтын зардлыг 12,370.3 мянган төгрөгөөр, 1 удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 23,212.6 мянган төгрөгөөр, хангамжийн зардлыг 40,890.9 мянган төгрөгөөр, засварын зардлыг 371,186.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 120,640.1 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 175,418.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 320,056.5 мянган төгрөгөөр, нийт 1,063,774.9 мянган төгрөгөөр бууруулж, тогтмол зардлыг 31,228.0 мянган төгрөгөөр, цалин, НДШ-ийг 45,138.2 мянган төгрөг, нийт 76,366.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 5,549,489.4 мянган төгрөгөөр хянан баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 358,367.8 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,191,122.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр болсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,907,841.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 4,825,938.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 81,902.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,825,938.7 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь албан томилолтын зардлыг 659.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 9,023.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр 10,881.5 мянган төгрөг, тогтмол зардлыг 12,121.8 мянган төгрөг, хангамжийн зардлыг 12,226.0 мянган төгрөг, тэтгэмж урамшууллын зардлыг 30,798.5 мянган төгрөг, нормативт зардлыг 43,192.9 мянган төгрөг, цалин, НДШ-ийн зардлыг 246,279.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	72207-80101 Үндсэн үйл ажиллагаа	5,130,276.5	4,801,777.7	328,498.8	93.6
2	72207-80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	54,959.5	24,161.0	30,798.5	44.0
3	72207-81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	5,886.0	-	5,886.0	-
	дүн	5,191,122.0	4,825,938.7	365,183.3	92.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн

гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл"-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 09 дүгээр сарын 22 өдрийн А/162 дугаар тушаалаар 103 орон тоотой ажиллахаар баталсныг Монгол Улсын Их хурлын 2025 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн “Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/197 дугаар тушаалаар 9 хувиар бууруулж 94 орон тоотой ажиллаж, 3,188,757.6 мянган төгрөгийн цалингийн санг төлөвлөснөөс гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 70, үйлчлэх 23, нийт 94 орон тоотой ажиллаж, нийт 2,991,273.1 мянган төгрөгийн цалингийн зардал зарцуулсан байна.
- Байгууллагын захирлын 2022 оны 01 сарын 14-ны А/06 дугаар тушаалаар баталсан хөдөлмөрийн дотоод журмын 6.1.5-д “Ажилчдын албан хаагчийн унаа хоолны мөнгийг төсөвт багтааж олгох ба үнийн өөрчлөлттэй уялдуулан тухайн үед нь шинэчилнэ” гэж заасны дагуу хоол, унааны хөнгөлөлтийн тарифыг 22.0 мянган төгрөгөөр тогтоож, 414,546.7 мянган төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 491,319.7 мянган төгрөгийн хоол унааны хөнгөлөлтийг олгож, батлагдсан төсвийг 76,773.0 мянган төгрөгөөр илүү зарцуулсан нь тайлант онд хоолны мөнгийг 25.0 мянган төгрөгөөр тооцож олгосноос шалтгаалсан байна.
- Гадаад томилолт, арга хэмжээний зардлыг төлөвлөөгүй, тайлант онд зардал гараагүй.
- Сургалт семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал гараагүй байна.
- Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулаагүй, зардал гараагүй.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас санхүүжүүлсэн 15,000.0 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 1,143,930.5 мянган төгрөгийн 2 ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 42,385.1 мянган төгрөгийн 1 ажлыг харьцуулалтын аргаар, 80,537.5 мянган төгрөгийн 7 бараа ажил үйлчилгээ шууд худалдан авалтаар, нийт

10 төрлийн бараа, үйлчилгээг 1,266,853.1 мянган төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр www.tender.gov.mn цахим системээр 472,385.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 бараа, ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар, 80,537.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 7 бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар, 14,143,930.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 бараа, ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, нийт 1,266,853.1 мянган төгрөгийн 10 бараа, ажил үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан 10 гүйцэтгэгчтэй 1,218,822.1 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 1,182,736.6 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өнөр бүл хүүхдийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Өнөр бүл хүүхдийн төв, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ихмонгол хөлөг ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Ш.Солонго, О.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж, захирал С.Тунгалаг, Чанарын хяналтын менежер С.Сожидмаа нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Өсөхжаргал, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Өнөр бүл хүүхдийн төв нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,243,242.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 52,432.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон хязгаарласан арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн системд 171 мэдээлэл байршуулахаас 167 мэдээлэл хугацаандаа байршуулж 4 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй, байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж үзсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Тайлант оны нээлттэй тендер, шууд худалдан авалтын тендерт шалгарсан бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай байгуулсан 26 гэрээнд захиалагч байгууллагыг төлөөлөн эд хариуцагч гэрээнд гарын үсэг зурж байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн дүгээр зүйлийн 4.1.38-д "Төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 1/-д " Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, үүрэг бүхий этгээдийг эд хариуцагч гэнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа үйлчилгээ худалдан авах аливаа гэрээ хэлэлцээрт уг асуудлыг хариуцсан ажилтныг томилон баталгаажуулж байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, авлага, зардлын данснуудад горим сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар илэрсэн 54,570.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг залруулсан. Үүнд:

- Шалгагдагч байгууллагын бараа материал, үндсэн хөрөнгөнд хяналтын түүвэрчилсэн тооллого гүйцэтгэхэд 54,570.0 мянган төгрөгийн хөрөнгөнд эд хариуцагч бүрээр хөрөнгийн карт хөтлөөгүй, хөрөнгийн кодолж бүртгээгүй; хөрөнгө биетээр байхгүй,
- Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын НХМаягт БМ-5 дугаар маягтыг хөтлөөгүйг;

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 8,991.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 7,113.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлснийг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	8,991.1	2	8,991.1	100.0
Албан шаардлага	2	7,113.4	2	7,113.4	100.0
Зөвлөмж	3	104,429.1	3	104,429.1	100.0
Нийт дүн	7	120,533.6	7	120,533.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн стандарт, Сангийн сайдын шинэчлэн баталсан заавар журмуудад нийцүүлэн шинэчлэн баталсан байдал, үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлсэн эсэх, шилэн дансны хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого, тооцоо бодолтыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 101,146.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 101,146.7 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Үр дүнгийн тайланд тайлагнасан цалин, хөдөлмөрийн хөлсний дүнг татвар, нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан дүнтэй тулган шалгахад НДШ-ийн тайланд 4,244.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тайланг бэлтгээгүй, тохируулгыг хийгээгүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайлан 96,902.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Эдгээр алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.3 гэж заасантай тус тус нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-3 “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа” УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф болон аудитын “Оршин байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна эрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 11,430,396.9 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 325.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 11,289,006.2 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 141,065.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 11,430,396.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 11,377,964.4 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тайлант онд 5 ажилтны албан томилолтоор ажилласан хугацаанд хоол, унааны олговор 325.0 мянган төгрөгийг албан томилолтын олговортой давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2.3-д "Хоолны зардал" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан олгосон хоолны хөнгөлөлт 325.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Өнөр бүл хүүхдийн төвийн ерөнхий захирлын 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/41 дүгээр тушаалаар хөрөнгийн тооллого хийх комисс нь батлагдсан ч 342 нэр төрлийн 10,680,217.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,586 нэр төрлийн 397,501.7 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлд хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, тооцоог бодож баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1.-д "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө";, 13 дугаар зүйлийн 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2/-т " Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/; 3/-т " Дуусаагүй үйлдвэрлэл, өөрийн үйлдвэрийн хагас боловсруулсан зүйл, үнэт цаасны тооллогыг улиралд 1 удаа / улирлын эцсийн сарын 25-наас/ ;4/-т "Мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал болон жижиглэн худалдаалах газар /дэлгүүр, цайны газар, ресторан, бар, зочид буудал гэх мэт/-т байгаа бараа, сав, боодлыг сар бүр /сар бүрийн 1-нээр/; 5/-д "Ажлын болон өсвөр, үржил, тэжээлд байгаа мал, амьтдыг жилд 1 удаа /12 дугаар сарын 15-ны/; гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийгээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Тайлант онд 8 байгууллагад 4,517.7 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." 70 дугаар зүйлийн 70.5-д "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийж тооцоо бодоогүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.3. Шалгагдагч байгууллагын асруулагчдын хоолны зарцуулалтыг давтан тооцоолоход 62,223.7 мянган төгрөгийг батлагдсан нормоос зөрүүтэй тооцсон, батлагдсан төсөвгүй 144,545.9 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар үйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;"; Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын"

Зардлын нормантив шинэчлэн батлах тухай 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/130 дугаар тушаалын 1,2,3,4,5 дугаар хавсралтаар баталсан норматив" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан норм нормативыг мөрдөж ажиллаагүй, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өнөр бүл хүүхдийн төвийн ерөнхий захирлын 2020 оны захирлын А/37 тоот тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинэчлэн батлагдсан заавар журам, стандарт, байгууллагын үйл ажиллагааны бүртгэл, тайлагналын онцлогт нийцээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар 3.1.9.-т "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг;" 20 дугаар зүйлийн 20.2.2-т"Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар 3.1.9.-т "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг;" 20 дугаар зүйлийн 20.2.2-т"Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: НБББББ-т шинээр батлагдсан стандарт, хууль, тогтоол, Сангийн сайдын 2025 оны А/03, 112 дугаар тушаалуудын дагуу өөрчлөлт оруулан батлуулж, мөрдөх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ашиглалтад байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 144,065.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр тайлагнаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", УСНББОУС 1-ын 63-т" Байгууллага нь тухайн үндсэн хөрөнгийн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц тийм өртөггүй хэсгүүдийг тусд нь элэгдүүлэхээр сонголт

хийж болно" гэж заасантай нийцээгүй санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хэмжилт, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Үр дүнгийн тайланд тайлагнасан цалин, хөдөлмөрийн хөлсний дүнг татвар, нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан дүнтэй тулган шалгахад НДШ-ийн тайланд 4,244.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасан байна.	1	4,244.0	-	-	1	4,244.0	1	4,244.0	-	-	-	-
2	Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тайланг бэлтгээгүй, тохируулгыг хийгээгүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайлан 96,902.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	96,902.6	0	-	1	96,902.6	1	96,902.6	-	-	-	-
	Дүн	2	101,146.6	0	-	2	101,146.6	2	101,146.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
1	Өнөр бүл хүүхдийн төвийн ерөнхий захирлын 2020 оны захирлын А/37 тоот тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинэчлэн батлагдсан заавар журам, стандарт, байгууллагын үйл ажиллагааны бүртгэл, тайлагналын онцлогт нийцээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
2	Өнөр бүл хүүхдийн төвийн ерөнхий захирлын 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/41 дүгээр тушаалаар хөрөнгийн тооллого хийх комисс нь батлагдсан ч 342 нэр төрлийн 10,680,217.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,586 нэр төрлийн 397,501.7 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлд хөрөнгийн тооллогын хуулийн хугацаанд хийгээгүй, тооцоог бодож баталгаажуулаагүй.	1	11,077,718.8	-	-	1	11,077,718.8	-	-	-	-	-	-

Өнөр бүл хүүхдийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	Ашиглалтад байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 144,065.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр тайлагнаагүй байна.	1	141,065.6	-	-			1	141,065.6	-	-	-
4	Тайлант онд 5 ажилтны албан томилолтоор ажилласан хугацаанд хоол, унааны олговор 325.0 мянган төгрөгийг албан томилолтын олговортой давхардуулан олгосон байна.	1	325.0	1	325.0			-	-	-	-	-
5	Тайлант онд 8 байгууллагад 4,517.7 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсан.	1	4,517.7	-	-	1	4,517.7	-	-	-	-	-
6	Шалгагдагч байгууллагын асруулагчдын хоолны зарцуулалтыг давтан тооцоолоход 62,223.7 мянган төгрөгийг батлагдсан нормоос зөрүүтэй тооцсон, батлагдсан төсөвгүй 144,545.9 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан байна.	1	206,769.7	-	-	1	206,769.7	-	-	-	-	-
	Дүн	6	11,430,396.9	1	325.0	3	11,289,006.2	2	141,065.6	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны нэгдсэн системд 171 мэдээлэл байршуулахаас 167 мэдээлэл хугацаандаа байршуулж 4 мэдээлэл хугацаа хоцроосон байна.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Тайлант оны нээлттэй тендер, шууд худалдан авалтын тендерт шалгарсан бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай байгуулсан 26 гэрээнд захиалагч байгууллагыг төлөөлөн эд хариуцагч гэрээнд гарын үсэг зурж байгуулсан байна.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-
	Нийт дүн	2	-	-	-	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 108/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/189/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өнөр бүл хүүхдийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 5 ажилтны албан томилолтоор ажилласан хугацаанд хоол, унааны олговорт нийт 325,000.00 /Гурван зуун хорин таван мянган/ төгрөгийг томилолтын зардалтай давхардуулан олгосон.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2.3-д "Хоолны зардал" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5 "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн;" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Өнөр бүл хүүхдийн төв нь хоол унааны олговрыг давхардуулан олгосон 325,000.00 /Гурван зуун хорин таван мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын төрийн санд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Өнөр бүл хүүхдийн төвийн захирал /М.Өлзийчимэг/, ахлах нягтлан бодогч /Б.Долзодмаа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0225 SAG-64.Docx

1526200066



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 516/A0150169

Улаанбаатар хот

САГ-2026/189/НА-СТА-ТШЗ.

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өнөр бүл хүүхдийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өнөр бүл хүүхдийн төвийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/41 дүгээр тушаалаар хөрөнгийн тооллого хийх комисс томилогдсон ч 342 нэр төрлийн 10,680,217,072.00 /Арван тэрбум зургаан зуун наян сая хоёр зуун арван долон мянга далан хоёр/ төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,586 нэр төрлийн 397,501,694.25 /Гурван зуун ерэн долоон сая таван зуун нэг мянга зургаан зуун ерэн дөрвөн төгрөг хорин таван мөнгө/ төгрөгийн бараа материалын үлдэгдэлд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийгээгүй, тооцоог бодож баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"; 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/"; 3-т "Дуусаагүй үйлдвэрлэл, өөрийн үйлдвэрийн хагас боловсруулсан зүйл, үнэт цаасны тооллогыг улиралд 1 удаа / улирлын эцсийн сарын 25-наас/; 4-т "Мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал болон жижиглэн худалдаалах газар /дэлгүүр, цайны газар, ресторан, бар, зочид буудал гэх мэт/-т байгаа бараа, сав, боодлыг сар бүр /сар бүрийн 1-нээр/, 5-д "Ажлын болон өсвөр, үржил, тэжээлд байгаа мал, амьтдыг жилд 1 удаа /12 дугаар сарын 15-ны/" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийгээгүй зөрчлийг таслан зогсоож, -биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өнөр бүл хүүхдийн төвийн захирал /М.Өлзийчимэг/, ахлах нягтлан бодогч /Б.Долзодмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
С.ТУНГАЛАГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-96.Docx

1526181091



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 515/А0150169

Улаанбаатар хот

СНГ-2026/189/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өнөр бүл хүүхдийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 8 байгууллагад 4,517,745.00 /Дөрвөн сая таван зуун арван долоон мянга долоон зуун дөчин таван/ төгрөгийн өр төлбөртэй гарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", 70 дугаар зүйлийн 70.5-д "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант онд өр төлбөр үүсгэдэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өнөр бүл хүүхдийн төвийн захирал /М.Өлзийчимэг/, ахлах нягтлан бодогч /Б.Долзодмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

С.ТУНГАЛАГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 514/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/789/НА-СТН-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өнөр бүл хүүхдийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шалгагдагч байгууллагын асруулагчдын хоолны зарцуулалтыг давтан тооцоолоход 62,223,744.25 /Жаран хоёр сая хоёр зуун хорин гурван мянга долоон зуун дөчин дөрвөн төгрөг хорин таван мөнгө/ төгрөгийг батлагдсан нормоос зөрүүтэй тооцсон, батлагдсан төсөвгүй баяр ёслол тэмдэглэхэд нийт 144,545,986.50 /Нэг зуун дөчин дөрвөн сая таван зуун дөчин таван мянга есөн зуун наян зургаан төгрөг тавин мөнгө/ төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар үйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Зардлын нормантив шинэчлэн батлах тухай 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/130 дугаар тушаалын 1,2,3,4,5 дугаар хавсралтаар баталсан норматив" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан норм, нормативыг мөрдөж ажиллаагүй, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өнөр бүл хүүхдийн төвийн захирал /М.Өлзийчимэг/, ахлах нягтлан бодогч /Б.Долзодмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-96.Docx

1526181095